

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаангом хот

2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: А.Нанжидмаа

Утас: 70453799, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	133
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	134
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	156
3.8 Аудитын гол асуудал.....	156
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ
З.АРИУНБАЯР ТАНАА

2022.02.21 № УВА-2022/57/НА-СГА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ



0200100060

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,801,678.25	62,432,620.63
31	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	128,000.00	128,000.00
31020	Төрийн сангийн харилцах	128,000.00	128,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,801,678.25	62,304,620.63
35100	Түүхий эд материал	8,502,480.0	21,423,485.0
35110	Тусгай зориулалттай материал	7,162,930.00	19,540,285.00
35130	Эм боох материал	1,339,550.00	1,883,200.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,863,315.50	4,576,608.50
35400	Хангамжийн материал	32,307,882.75	36,304,527.13
35410	Бичиг хэргийн материал	780,320.00	1,476,202.00
35420	Аж ахуйн материал	29,934,193.13	33,043,601.13
35460	Хүнсний материал	1,593,369.62	1,784,724.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,828,289,512.41	1,771,701,383.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,828,289,512.41	1,771,701,383.80
39200	Биет хөрөнгө	1,705,182,027.07	1,649,505,597.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,634,987,661.17	1,634,987,661.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72,627,393.84	-108,941,090.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	176,313,888.91	176,313,888.91
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,088,194.36	-100,740,972.08
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	100,984,074.13	117,003,567.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-70,507,040.18	-83,682,414.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,937,190.00	31,337,190.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,076,982.76	-21,031,056.54
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,258,824.00	4,258,824.00
39300	Биет бус хөрөнгө	123,107,485.34	122,195,786.52
39301	Програм хангамж	6,417,692.31	6,417,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,306,206.97	-6,217,905.79
39303	Бусад биет бус хөрөнгө	121,996,000.00	121,996,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,873,091,190.66	1,834,134,004.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,873,091,190.66	1,834,134,004.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,873,091,190.66	1,834,134,004.43
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,687,783.90	892,687,783.90
51200	Хуримтлагдсан үр дүн	436,425,541.17	397,468,354.94
51210	Өмнөх үеийн үр дүн	436,425,541.17	436,425,541.17
51220	Тайлант үеийн үр дүн	-	-38,957,186.23
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	543,977,865.59	543,977,865.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,873,091,190.66	1,834,134,004.43

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	823,502,242.91	812,807,143.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,999,842.91	24,449,640.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,999,842.91	24,449,640.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,999,842.91	24,449,640.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,500.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	90,987,342.91	24,449,640.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,502,400.00	788,357,503.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	731,102,400.00	766,907,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	731,102,400.00	766,907,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,400,000.00	21,450,403.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,400,000.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		17,135,403.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		315,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	799,002,498.09	851,764,329.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	799,002,498.09	851,764,329.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	796,274,375.62	845,801,380.81
210	ЦАЛИН ХӨЛС, НЭМЭГДЭЛ, НДШ	522,858,801.44	546,815,887.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,413,046.27	534,783,329.76
210101	Үндсэн цалин	321,177,335.15	350,278,356.20
210102	Нэмэгдэл	187,235,711.12	181,791,900.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,000,000.00	1,033,073.56
210104	Урамшуулал	1,000,000.00	1,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,445,755.17	12,032,557.25
210201	Тэтгэврийн даатгал	960,855.17	
210205	Эрүүл мэндийн даатгал	10,484,900.0	12,032,557.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,065,771.91	105,348,966.57
210301	Гэрэл, цахилгаан	11,617,808.91	12,241,648.57
210302	Түлш, халаалт	78,288,275.00	79,751,760.00
210303	Цэвэр, бохир ус	17159688	13,355,558.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,300,019.0	25,366,591.0
210401	Бичиг хэрэг	3,586,100.00	2,482,700.00
210402	Тээвэр, шатахуун	18,760,050.00	15,776,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,994,200.00	5,093,141.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	418,300.00	377,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,541,369.00	1,637,340.00
2105	Нормативт зардал	31,717,694.38	24,316,307.62
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,427,950.00	1,222,000.00
210502	Хоол, хүнс	28,125,413.98	19,920,265.62

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,164,330.40	3,174,042.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,784,800.00	58,837,968.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	102,000.00	117,500.00
210604	Урсгал засвар	32,682,800.0	58,720,468.00
2107	Томилолт, зочны зардал	1,860,500.00	1,030,000.00
210702	Дотоод албан томилолт	1,860,500.00	1,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,876,336.00	6,128,239.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	849,900.00	3,040,000.00
210802	Аудит баталгаажуулалт	224,000.00	224,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,436.00	283,959.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	110,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,203,500.00	818,500.00
210807	Газрын төлбөр	350,000.00	1,651,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,810,452.89	77,957,421.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	474,000.00	949,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,886,452.89	77,007,621.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,728,122.47	5,962,948.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,230,000.00	5,192,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	5,192,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,498,122.47	770,948.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,498,122.47	770,948.42
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	24,499,744.82	-38,957,186.23
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	24,499,744.82	-38,957,186.23

2.3 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01р сарын 01-нээрх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	411,925,796.35	1,848,591,445.84
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	411,925,796.35	1,848,591,445.84
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			24,499,744.82	24,499,744.82
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	436,480,541.17	1,873,146,190.66
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	436,480,541.17	1,873,146,190.66
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			-38 957,186.23	-38 957,186.23
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	892,687,783.90	543,977,865.59	397,468,354.94	1,834 134,004.43

2.4 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	732,514,900.00	788,357,503.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,500.00	
120	Нийтлэг татварын бус орлого	12,500.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,500.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	732,502,400.00	788,357,503.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	731,102,400.00	766,907,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	731,102,400.00	766,907,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,400,000.00	21,450,403.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,400,000.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		17,135,403.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		315,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	720,190,900.00	774,337,910.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	720,190,900.00	774,337,910.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,462,777.53	768,374,961.58
210	Цалин хөлс, нэмэгдэл, ндш	522,850,319.62	546,815,887.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,413,046.27	534,783,329.76
210101	Үндсэн цалин	321,177,335.15	350,278,356.20
210102	Нэмэгдэл	187,235,711.12	181,791,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,000,000.00	1,033,073.56
210104	Урамшуулал	1,000,000.00	1,680,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,437,273.35	12,032,557.25
210201	Тэтгэврийн даатгал	952,373.35	-
210205	Эрүүл мэндийн даатгал	10,484,900.00	12,032,557.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,065,771.91	105,348,966.57
210301	Гэрэл, цахилгаан	11,617,808.91	12,241,648.57
210302	Түлш, халаалт	78,288,275.00	79,751,760.00
210303	Цэвэр, бохир ус	17,159,688.00	13,355,558.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,131,400.00	24,906,423.00
210401	Бичиг хэрэг	3,501,400.00	2,475,532.00
210402	Тээвэр, шатахуун	18,160,050.00	14,776,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,994,200.00	5,093,141.00
210405	Хог хаягдал зайлуулах	418,300.00	377,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,057,450.00	2,184,340.00
2105	Нормативт зардал	23,948,900.00	21,334,020.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	718,700.00	1,222,400.00
210502	Хоол, хүнс	23,230,200.00	20,111,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,129,550.00	75,881,219.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	12,824,000.00	12,180,001.00
210602	Тавилга	-	4,400,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	190,600.00	190,750.00
210604	Урсгал засвар	29,114,950.00	59,110,468.00
2107	Томилолт, зочны зардал	1,765,500.00	1,030,000.00
210702	Дотоод албан томилолт	1,765,500.00	1,030,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,876,336.00	6,128,239.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	849,400.00	3,040,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	224,000.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар	194,436.00	283,959.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	110,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,203,500.00	818,500.00
210807	Газрын төлбөр	350,000.00	1,651,780.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,019,000.00	949,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	569,000.00	949,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,728,122.47	5,962,948.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,230,000.00	5,192,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	5,192,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,498,122.47	770,948.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,498,122.47	770,948.42
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,324,000.00	14,019,593.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,324,000.00	14,019,593.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,324,000.00	14,019,593.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,324,000.00	14,019,593.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,324,000.00	14,019,593.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-12,324,000.00	-14,019,593.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	128,000.00	128,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	128,000.00	128,000.00

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	766,907,100.00	766,451,151.58	455,948.42	99.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	763,485,100.00	763,259,151.58	225,948.42	99.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	216,524,700.00	216,443,264.57	81,435.43	99.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	534,891,500.00	534,783,329.76	108,170.24	99.98
210101	Үндсэн цалин	350,309,600.00	350,278,356.20	31,243.80	99.99
210102	Нэмэгдэл	181,791,900.00	181,791,900.00	-	100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,110,000.00	1,033,073.56	76,926.44	93.07
210104	Урамшуулал	1,680,000.00	1,680,000.00		100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,068,900.00	12,032,557.25	36,342.75	99.70
210205	Эрүүл мэндийн даатгал	12,068,900.00	12,032,557.25	36,342.75	99.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,349,900.00	105,348,966.57	933.43	100
210301	Гэрэл, цахилгаан	12,241,700.00	12,241,648.57	51.43	100
210302	Түлш, халаалт	79,752,600.00	79,751,760.00	840	100
210303	Цэвэр, бохир ус	13,355,600.00	13,355,558.0	42	100
2104	Хангамж, бараа материалын зардал	23,426,900.00	23,406,423.00	20,477.00	99.91
210401	Бичиг хэрэг	2,720,000.00	2,475,532.00	244,468.00	91.01
210402	Тээвэр, шатахуун	13,168,000.00	13,276,410.00	108,410.00	100.82
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,028,300.00	5,093,141.00	-64,841.00	101.29
210405	Хог хаягдал зайлуулах	377,100.00	377,000.00	100.00	99.97
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,133,500.00	2,184,340.00	-50,840.00	102.38
2105	Нормативт зардал	21,345,000.00	21,334,020.00	10,980.00	99.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,22,900.00	12,22,400.00	500	99.96
210502	Хоол, хүнс	20,122,100.00	20,111,620.00	10,480.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,746,100.00	60,745,816.00	284.00	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,900,000.00	3,899,998.00	2	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	191,000.00	190,750.00	250	99.87
210604	Урсгал засвар	56,655,100.00	56,655,068.00	32	100
2107	Томилолт, зочны зардал	1,058,300.00	1,030,000.00	28300.00	97.33
210702	Дотоод албан томилолт	1,058,300.00	1,030,000.00	28300.00	97.33
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,148,700.00	4,128,239.00	20461.00	99.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,040,000.00	1,040,000.00		100
210802	Аудит баталгаажуулалт	224,000.00	224,000.00		100
210803	Тээврийн хэрэгслийн татвар	284,000.00	283,959.00	41	99.99
210804	Тээврийн хэрэгслийн оношилгоо	130,400.00	110,000.00	20400.00	84.36
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	818,500.00	818,500.00		100
210807	Газрын төлбөр	1,651,800.00	1,651,780.00	20	100

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	449,800.00	449,800.00		100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	449,800.00	449,800.00		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,422,000.00	3,192,000.00	230,000.00	93.28
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	230,000.00		230,000.00	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	230,000.00		230,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,192,000.00	3,192,000.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,192,000.00	3,192,000.00		100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	766,907,100.00	766,451,151.58	455948.42	99.94
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	766,907,100.00	766,451,151.58	455948.42	99.94
310001	Улсын төсвөөс санхүүжих	766,907,100.00	766,451,151.58	455948.42	99.94

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		21,135,403.00		
21	УРСГАЛ ЗАРДАЛ		19,135,403.00		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		19,135,403.00		
2104	Хангамж, бараа материалын зардал		1,500,000.00		
210401	Бичиг хэрэг				
210402	Тээвэр, шатахуун		1,500,000.00		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,135,403.00		
210601	Багаж, техник, хэрэгсэл		8,280,003.00		
210602	Тавилга		4,400,000.00		
210604	Урсгал засвар		2,455,400.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,000,000.00		
21801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,000,000.00		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		5,000,000.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		500,000.00		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,000,000.00		
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,000,000.00		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,000,000.00		
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		21,135,403.00		
31	Нэмэлт санхүүжилтийн орлого		21,135,403.00		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,000,000.00		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		17,135,403.00		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		315,000.00		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/60 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь “Шүүхийн шийдвэрийг нэг мөр биелүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын бодлого шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 6.3 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 851.7 сая төгрөгийн 1 хувь буюу 8.5 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 6.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38,957.2 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	128.0	128.0	0
Авлага	0	0	0
Бараа материал	44,673.7	62,304.6	17,630.9
Үндсэн хөрөнгө	1,828,289.5	1,771,701.4	-56,588.1
Нийт хөрөнгө	1,873,091.2	1,834,134.0	-38,957.2
Өр төлбөр	1,873,091.2	1,834,134.0	-38,957.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,873,091.2	1,834,134.0	-38,957.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,873,091.2	1,834,134.0	-38,957.2

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс 128.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 62,304.6 мянган төгрөг болж 17,630.9 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал дансанд хөрөнгө бүртгэж орлогод авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,771,701.4 мянган төгрөг болж 56,588.1 мянган төгрөгөөр буурсан нь хандиваар хүлээн авсан 6,399.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр 14,019.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авч, тайлант онд 77,007.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 14,019.6 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 6,399.9 мянга, нийт 20,419.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,834,134.0 мянган төгрөг болж 38,957.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн хасагдсанаас шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө буурсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 10,682.6 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө нэмэгдсэн, бараа материал дээд шатны төсөв захирагчаас шилжүүлж авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 53,211.8 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, түлш халаалт, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлууд байна.

2021 онд урт болон богино хугацаат өр төлбөр үүсээгүй болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 973,190.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 973,190.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 206,283.3 мянган төгрөгөөр бууруулж 766,907.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 766,907.1 мянган төгрөгийн төсөв баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 766,907.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 763,259.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 766,451.1 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 4,000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 17,135.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 315.0 мянга, нийт 21,450.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Тээвэр шатахуун 1,500.0 мянга, багаж техник хэрэгсэл 8,280.0 мянга, тавилга 4,400.0 мянга, урсгал засвар 2,455.4 мянга, хичээл үйлдвэрлэл 500.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 2,000.0 мянга нийт 21,450.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 146, хугацаа хоцроосон 3 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

2022 оны 02 сарын 14-ний өдөр

